



**BASALTWOOL**  
МОНГОЛ БАЗАЛТ ХК

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАН 2024 ОН**



## КОМПАНИЙН ТУХАЙ



## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

### Оноосон нэр:

Монгол Базальт ХК

### Үйл ажиллагааны чиглэл:

Чулуун хөвөнгийн  
үйлдвэр, үйлдвэрийн  
хүчин чадал: Цагт 2 тн

### Байгуулагдсан огноо:

2007

### Хаяг:

Монгол улс, Улаанбаатар  
хот, Сүхбаатар дүүрэг, 1-р  
хороо, Фламинго тауэр, 403  
тоот

### Вэбсайт, фэйсбүүк хаяг:

[www.basaltwool.mn](http://www.basaltwool.mn)  
Mongol Basalt JSC

### Утас, и-майл хаяг:

75114444  
[monbasalt@rockwool.mn](mailto:monbasalt@rockwool.mn)



## УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ

### ТУЗ-ийн дарга:

Л.Ариунболд

### Гүйцэтгэх захирал:

А.Энхгэрэл

### Ажилчдын тоо:

92



## ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

### Хувьцааны симбол код:

MSE:MBW / 544

### МХБиржид бүртгэгдсэн:

2018.04.05

### Нийт гаргасан хувьцаа:

56,417,000 ширхэг



# ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



**Л.АРИУНБОЛД**  
ТУЗ-ИЙН ДАРГА

## ИРЭЭДҮЙГ ХАМТДАА БҮТЭЭЦГЭЭ

### ЭРХЭМ ХҮНДЭТ АЖИЛЧИД, ТҮНШҮҮД, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ЭЭ,

Монгол Базальт ХК-ийн ТУЗ-ийн даргын хувьд та бүхэндээ мэндчилгээ дэвшүүлье.

Бид хамтдаа гайхалтай зүйлийг бүтээж байна. Манай компани тогтвортой өсөлтийг харуулж, инноваци, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаагаараа салбартаа тэргүүлэгч хэвээр байна. Энэ нь зөвхөн санхүүгийн үзүүлэлтээр хэмжигдэхгүй, харин бидний нийгэм, байгаль орчинд үзүүлэх эерэг нөлөөллөөр батлагдаж байна.

Бидний баримталдаг гол зарчим бол чанар болон бүтээмж юм. ISO сертификатууд нь үүний баталгаа юм. Гэхдээ чанар гэдэг зөвхөн бүтээгдэхүүнээр хязгаарлагдахгүй. Ажилчдынхаа аюулгүй байдал, эрүүл мэнд, хөгжил, нийгмийн хариуцлага гээд бүхий л үйл ажиллагаандаа бид чанарыг эрхэмлэдэг.

Бид хариуцлагатай үйлдвэрлэгч, нийгмийн сайн сайхны төлөө хувь нэмрээ оруулагч байхыг зорьдог. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих, барилгын салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах зэрэг нь бидний нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагын нэгээхэн хэсэг юм.

Цаашид ч бид хамтдаа илүү ихийг бүтээнэ гэдэгт итгэлтэй байна.

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



**А.ЭНХГЭРЭЛ**  
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

## ӨСӨЛТ, ХӨГЖИЛ БА ШИНЭ БОЛОМЖУУД

### Эрхэм хүндэт харилцагч та бүхэндээ,

Монгол Базальт ХК-ийн гүйцэтгэх захирлын хувьд компанийнхаа өнгөрсөн жилийн амжилтыг та бүхэнтэй хуваалцаж байгаадаа баяртай байна.

Бид тогтвортой өсөлтийг хадгалж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн, шинэ зах зээлд нэвтэрч байна. Энэ нь зөвхөн манай хамт олны хүчин чармайлтын үр дүн биш, олон гадна дотны хамтарсан хөтөлбөр зэрэг гадаад түншүүдтэйгээ үр бүтээлтэй хамтран ажилласны үр шим юм.

Бид үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлж, бүтээгдэхүүний өртгийг бууруулж чадсанаар зах зээлд өрсөлдөх чадвараа улам бэхжүүлж байна. Гэхдээ бид зөвхөн ашгийн төлөө бус, хариуцлагатай, тогтвортой бизнесийн зарчмуудыг баримталдаг. ESG үнэлгээ, ISO стандартууд нь үүнийг нотолж байна.

Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, зах зээлээ тэлэх нь бидний гол зорилтуудын нэг. Мөн бид үндэсний их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж, барилгын салбарын боловсон хүчнийг бэлтгэх, инновацийг дэмжихэд хувь нэмрээ оруулж байна.

Монгол Базальт ХК нь зөвхөн өнөөдрийн амжилтаар зогсохгүй, цаашид улам хөгжин дэвших, Монгол Улсынхаа хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулах болно.

# КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

МОНГОЛ БАЗАЛЪТ” ХК нь Монголын хүнд аж үйлдвэрийн салбараас анхны Байгаль орчин нийгэм засаглалын үнэлгээ /ESG/ хийлгэсэн, дэлхийн аж үйлдвэрийн IV хувьсгал, хөгжлийн тэргүүлэх чиглэлд судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлж, шинэ технологи, инновацийн шийдэл бүхий үйлдвэрлэлийг нэвтрүүлэн, хүн төрөлхтний өмнө тулгамдаж буй хүлэмжийн хий, агаарын бохирдол, эрчим хүчний зардал, дулааны алдагдлыг бууруулах чиглэлээр олон зорилтот төсөл хөтөлбөр амжилттай хэрэгжүүлж буй үндэсний томоохон үйлдвэрлэгч юм.

Бид галт уулын чулуулгийг чулуун хөвөн болгон хувиргаж, нийгэмд тулгарч буй уур амьсгалын өөрчлөлтийн томоохон сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, орчин үеийн амьдралыг баяжуулж, аюулгүй, эрүүл, уур амьсгалд илүү тэсвэртэй, тотвортой нийгмийг бий болгох шинэ боломжийг үргэлж эрэлхийлдэг.



## АЛСЫН ХАРАА

Галт уулын чулуулгийг чулуун хөвөн болгон хувиргаж, нийгэмд тулгарч буй уур амьсгалын өөрчлөлтийн томоохон сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, орчин үеийн амьдралыг баяжуулж, аюулгүй, эрүүл, уур амьсгалд илүү тэсвэртэй, тотвортой нийгмийг цогцлооно.



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Инноваци шингэсэн үйлдвэрлэл технологиороо салбараа манлайлан хөгжүүлж, хүний амьдрах орчинг тав тухтай, барилга хийцийн эрсдэлгүй, байгальд хамгийн ойр байлгаж, ирээдүй хойчдоо өвлүүлэн үлдээх үнэ цэнэ бүхий баталгаат хөрөнгө оруулалтыг бий болгоно.



# ТОВЧ ТҮҮХ




**2009**  
Чулуун хөвөнгийн үйлдвэр байгуулж, анхны бүтээгдэхүүн ээ зах зээлд нийлүүлсэн.



**2019**  
Үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг өрнүүлж, хүчин чадлаа 1.5 дахин нэмэгдүүлсэн. Базальт чулуун хөвөн хөрсний судалгааг эхлүүлсэн



**2022**  
Базальт файбер арматур үйлдвэрлэх технологийг нэвтрүүлж, Монголын анхны базальт файбер арматурын үйлдвэр байгуулсан.



**2024**  
Шүршдэг базальт дулаан тусгаарлагч материалын үйлдвэр, техник технологи бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлсэн



**2007**

Монгол Базальт ХК-ийн ТУЗ-ийн дарга, үүсгэн байгуулагч Л.Ариунболд Чулуун хөвөнгийн үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулсан.



**2013**

Дулааны шугам хоолойн дулаалга үйлдвэрлэх СТУ дулаалгын технологийг нэвтрүүлж, Термобазальт үйлдвэрийг байгуулсан.



**2021**

Чулуун хөвөнд суурилсан инновацийн Базальт арматур, Базальт сэндвич, Грөвүүл 3 төсөл амжилттай хэрэгжүүлсэн.




**2023**

Базальт кассет сэндвич хавтан үйлдвэрлэх технологийг боловсруулж, үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн.




**БАРИЛГЫН САЛБАРЫН ТОЙМ**



# БАРИЛГЫН САЛБАРЫН ТОЙМ

Барилгын салбар бол аль ч улсын эдийн засагт асар их нөлөө үзүүлж буй өнөөгийн хамгийн чухал салбаруудын нэг юм. Манай улсын ДНБ-ийн 3 орчим хувийг барилгын салбар дангаараа эзэлж байгаа бол шууд болон шууд бусаар нийт 100 орчим мянган хүн ажиллаж, хөдөлмөрлөж байна. Шинэ барилга баригдах бүрд түүнийг дагаад барилгын материал, тавилга, ахуйн хэрэглээний бүхий л зүйлсийн худалдан авалт нэмэгдэж, эдгээрийг үйлдвэрлэж, худалдан борлуулж байгаа байгууллагуудын бараа бүтээгдэхүүн эргэлтэд орж байдаг.

ДНБ-ий салбарын бүтэц (2016-2023)



Эх сурвалж: Real Estate Sector study for MASD /2023/

## Барилгын салбарын макро үзүүлэлтүүдийн тойм

Эдийн засгийн статистик мэдээнд тулгуурлан барилгын салбарыг дүгнэвэл:

- 2023 оны байдлаар барилгын салбар нь ДНБ-ийн 2.9 хувийг эзэлж байсан бол жилийн өсөлт нь 0.6 хувь байсан байна. Тус салбарын өсөлт нь ДНБ-ийн өсөлтийн 1 хүрэхгүй хувийг бүрдүүлж байгаагаас гадна ДНБ-д эзлэх хувь нь 2020 оноос хойш тасралтгүй буурсан үзүүлэлттэй байна.
- Цар тахлаас шалтгаалан салбар нь 2021 онд 22.8 хувиар буурсан бөгөөд одоог хүртэл цар тахлын өмнөх түвшинд хүрээгүй байна. Түүнчлэн, салбарын өсөлт нь төрөөс хэрэгжүүлж буй төсөл, барилгын ажлаас ихээхэн хамааралтай байдаг.
- Салбарын бүтээмж нь 2023 оны байдлаар 11.9 сая төгрөг байсан бөгөөд энэ нь улсын дундаж бүтээмжээс 2.1 дахин бага үзүүлэлт юм.
- 2023 оны байдлаар нийт 4.41 их наяд төгрөгийг барилгын объектын төсөвт өртөгт зарцуулсан бөгөөд үүнээс орон сууцанд зарцуулсан нь 2.06 их наяд төгрөг байна. 2020 оноос хойш орон сууцны барилгын тоо буурч байгаа ч төсөвт өртөг нь ихсэж байгаа бөгөөд энэ нь илүү өндөр өртөгтэй, том талбайтай орон сууцны барилга баригдах болсонтой холбоотой байна.
- 2022 оны байдлаар нийт 77,527 ажилтан барилгын салбарт ажиллаж байсан бөгөөд энэ нь нийт ажиллагсдын 6.6 хувийг эзэлж байна. 2022 онд улсын дундаж цалин 1.5 сая төгрөг байсан бол барилгын салбарын дундаж цалин 1.43 сая төгрөг байсан байна.

## БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН НИЙЛҮҮЛЭЛТ

Монгол Улсын дотоодын барилгын материалын үйлдвэрүүд цемент, шохой, бетон зуурмаг, төмөр бетон эдлэл, дулаан тусгаарлах материал (хөөсөн полистирол хавтан, эрдэс хөвөн гэх мэт), барилгын засал чимэглэлийн материал, ердийн тоосго, зарим нэр төрлийн ган туйван, нийлэг мяндсан арматур, ган бөмбөлөг, явган замын тохижилт хийц эдлэл зэрэг материалыг голчлон үйлдвэрлэж байна. Харин цемент, арматурын төмөр, хуванцар хаалга цонх, сэндвич болон гипсэн хавтан, чулуун хавтан зэрэг зарим гол нэр төрлийн материалыг импортоор авч байна.

2021-2022 оны дунджаар, нийт барилгын материалын нийлүүлэлтэд ган туйван 35.0%, цувимал төмөр 7.0%, бусад төмөр хийц эдлэл 8.2% тус тус эзэлж байна. Үүний дараа барилгын материалын нийлүүлэлтэд цемент ба бетоноор хийсэн бүтээгдэхүүн 14.4%, мод, модон эдлэл 13.0%, цемент 9.4%-ийг тус тус эзэлж байна. Хуванцар хоолой, хуванцар цонх, хаалга, хөнгөн цагаан бүтээгдэхүүн, дулаан тусгаарлах материал, цонх ба ханын шил, хайрга, дайрга, элс зэрэг бүтээгдэхүүний нийлүүлэлт 1.2%-аас 3.3%- ийг эзэлж байгаа бол зэс утас ба хоолой, барилгад хэрэглэгдэх цавуу, хуурай хольц, бетоны химийн нэмэлт нь тус бүрдээ нийт нийлүүлэлтийн 1% хувь хүрэхгүй хэсгийг бүрдүүлж байна.

Барилгын материалын нийлүүлэлт, тэрбум төгрөг

БТКУС-ийн код	Барилгын материал	2021	2022
2517	Хайрга, дайрга, элс	13.2	18.1
2523	Цемент	154.0	190.6
3506	Барилгад хэрэглэгдэх цавуу, хуурай хольц	0.6	0.9
3824	Бетоны химийн нэмэлт	2.3	32.9
3917	Хуванцар хоолой	40.6	77.4
3925	Хуванцар цонх, хаалга	36.3	54.1
4411	Мод, модон эдлэл	168.8	168.8
6806	Дулаан тусгаарлах материал	15.4	23.7
6810	Цемент, бетоноор хийсэн бүтээгдэхүүн	212.9	310.9
6902	Керамик	5.3	11.5
7016	Шил, шилэн эдлэл	24.0	18.8
7213	Цувимал төмөр	116.0	139.8
7214	Ган туйван	519.3	758.8
7208	Бусад төмөр хийц эдлэл	107.8	191.8
7412	Зэс	4.3	5.8
7610	Хөнгөн цагаан	33.7	54.7
	Нийт	1,459	2,198


Эх сурвалж: БХБЯ болон ГЕГ-ын статистик мэдээлэлд үндэслэсэн судлаачийн тооцоо

# БАРИЛГЫН САЛБАРЫН ТОЙМ

## БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ БА ИМПОРТЫН ХАРЬЦАА

2021 онд нийт 1,476.2 тэрбум төгрөгийн нийлүүлэлт хийгдсэний 962.3 тэрбумыг импорт, 492.0 тэрбумыг дотоодын үйлдвэрлэл бүрдүүлжээ. Харин 2022 онд 2,164.8 тэрбум төгрөгийн нийлүүлэлт хийгдсэний 1,519.4 тэрбумыг импорт, 675.9 тэрбумыг дотоодын үйлдвэрлэлээс бүрдүүлжээ. 2021-2022 оны дунджаар барилгын материалын нийт нийлүүлэлтийн үнийн дүнд импортын эзлэх хувь 68.2 хувь, дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувь 31.8% байна. Энэ нь барилгын материалын нийлүүлэлт импортоос хамаарах хамаарал маш их байгааг илтгэж байна.

### Барилгын материалын нийлүүлэлтэд үйлдвэрлэл ба импортын эзлэх хувь, 2021-2022 оны дундаж



Эх сурвалж: БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА 2023 /БХБЯ болон ГЕГ-ын статистик мэдээлэлд үндэслэсэн судлаачийн тооцоо/

## БАРИЛГЫН ДУЛААЛГЫН МАТЕРИАЛ

Монгол улс нь дотоодын барилгын материалын хэрэглээний 70 гаруй хувь болох импортоор 43,000 тонн орчим барилгын дулаалгын материал худалдаж авдаг бөгөөд дийлэнх хувь барилгын дулаалгын материал нь чанарын шаардлага хангаагүйгээс зарим барилгуудын дулаан хадгалалт, дуу чимээ, тусгаарлалт, чийг нэвтрэлт, манай орны цаг уурийн нөхцөлд тэсвэргүй, галын аюулгүй байдал зэрэг нь барилгын насжилт болоод чанарт сөргөөр нөлөөлдөг. 2021-2022 оны дунджаар барилгын материалын нийт нийлүүлэлтийн үнийн дүнд импортын эзлэх хувь 68,2 хувь дотоодын үйлдвэрлэлийн 31,8 хувь байна. Энэ нь барилгын материалын нийлүүлэлт импортоос ихээхэн хамаарч байна. Иймд Улаанбаатар хотод тулгараад байгаа тэргүүлэх чиглэл бол уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, эрүүл аюулгүй, эко ногоон хот болох явдал юм. Ногоон хот болохын тулд иргэдийн хандлага болоод амьдрах орчин нөхцлийг сайжруулахад хүн бүрийн оролцоог хангах нь хамгийн чухал юм.

Сүүлийн жилүүдэд банк санхүүгийн байгууллагуудад ногоон зээлийн үйлчилгээ нэвтэрч, барилгын салбарт 2021 онд барилгын эрчим хүчний гэрчилгээ олгох журам батлагдсанаар барилга байшинг дулаан алдагдалгүй байх, байгаль экологид үзүүлэх нөлөөлөл, эрүүл мэндэд ээлтэй байх зэрэг шаардлагууд барилга архитектурын зураг төслийн шатнаас нь эрчим хүчний хэмнэлттэй байх, дулаан алдагдалгүй байх зэрэг шаардлага дээр үндэслэж барилгын эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээг олгодог болсон. Иймд эрчим хүчний хэмнэлттэй барилга барихаар төлөвлөж байгаа бол өөрийн газрын онцлог, цаг уур орчин нөхцөлд тохирсон барилгын хийцлэл, дулаан алдагдалгүй байшин барихад барилгын дулаалгын материалын сонголт маш чухал нөлөөтэй.

### ДУУ, ДУЛААН ТУСГААРЛАХ МАТЕРИАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Монгол Улсын барилгын салбар барилгын материал үйлдвэрлэл болох дуу, дулаан тусгаарлагч материал нь 60 гаруй хувийг импортоор хангадаг. Дулаалгын материалын гадаад худалдааны импортыг БНХАУ, ОХУ хөрш хоёр орноос ус, чийг тусгаарлах дулаалгын материалууд, эрдэст хөвөн, XPS хөөсөнцөр хавтан, пеноплекс хөөсөнцөр хавтан зэргийг түлхүү оруулж ирдэг. Дотоодын дулаалгын материал үйлдвэрлэлд голчлон хөөсөн полистирол EPS хөөсөнцөр хавтангийн үйлдвэрүүд тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж, дотоодын барилгын дулаалгын материалын зах зээлийг хангаж байна.

Манай улсын 2050 он хүртэлх урт хугацааны хөгжлийн бодлогод барилгын материалын үйлдвэрлэлийн талаар тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн байдаг.

- Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох” зорилтын 2-р үе шат буюу 2031-2040 онд барилгын материалын үйлдвэрлэлийн хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх үе шат луу шилжихээр төлөвлөжээ.
- Мөн барилгын материалыг боловсруулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх,
- Импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжих,
- Зорилт 8.1-ийн 3-р үе шатад ногоон технологид суурилсан хөнгөн үйлдвэр, барилгын материалын үйлдвэрлэлийн кластер төвүүдийг хөгжүүлэхээр төлөвлөжээ.

# БАРИЛГЫН САЛБАРЫН ТОЙМ

## Гол нэр төрлийн барилгын материалын 2030 он хүртэлх хэрэгцээ (прогноз)

№	Барилгын материал	Нэгж	Оноор (биет хэмжээ)				
			2017 суурь он	2020	2025	2027	2030
1	Арматур	Мян.тн	176.2	2462.3	3543.2	4098.4	5098.5
2	Тоосго	Сая.ш	77.4	102.7	1477.8	160.4	199.5
3	Хаалга, цонх	Мян.м2	325.9	432.1	621.8	674.8	839.5
4	Угсармал төмөр бетон бүтэц	Мян.м3	239.9	318.1	457.7	496.8	618.0
5	Бетон зуурмаг	Сая.м3	1.4	1.9	2.7	2.9	3.6
6	Цемент	Сая.тн	1.3	1.8	2.5	2.8	3.4
7	Хөнгөн бетон гулдмай	Мян.м3	337.0	446.8	643.0	697.8	868.1
8	Эрдэс хөвөн	Мян.м3	15.3	20.3	29.2	31.6	39.4
9	Хөөсөн полистирол EPS	Мян.м3	353.3	468.4	674.1	731.6	910.1
10	Хуванцар хоолой	Мян.км	1.5	2.1	3.0	3.2	4.0
11	Барилгын элс хайрга	Сая.м3	1.2	1.7	2.4	2.6	3.2
12	Шохой	Мян.тн	169.3	224.4	322.9	350.5	436.0

Эх сурвалж: БХБЯ, БМҮХ, Барилгын материалын үйлдвэрүүдийн мэдээллийн товхимол-2023



## НОГООН БАРИЛГЫН САНХҮҮЖИЛТ БУЮУ ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Барилгын салбарын хувьд ногоон барилгын үнэлгээний систем буюу ногоон барилгын гэрчилгээжүүлэлт нь баталгаа болно. Гэрчилгээжүүлэлтээр тухайн төсөл ашиглалтын зардлыг хэрхэн бууруулж, үнэ цэнийн өсөлтийг хэрхэн бий болгож, хүлэмжийн хийг хэрхэн бууруулж, байгаль орчин хүний эрүүл мэндэд хэрхэн эерэгээр нөлөөлж, нийгмийн сайн сайхны төлөө хэрхэн ажиллаж байна вэ гэдгийг үнэлэн тодорхойлсон байдаг учир тогтвортой ногоон санхүүжилтийн хариулт болдог.

Сүүлийн үед хөрөнгө оруулагчид, банк санхүүгийн байгууллагууд тодорхой нэр төрлийн ногоон барилгын гэрчилгээжүүлэлтийг авсан болон авахаар төлөвлөгдөж буй төслүүдэд хөрөнгө оруулалтыг өгөх болно гэдгээ зарлаад байгаа. 2021 оны байдлаар дэлхий даяар нийт 4.2тэрбум метр квадрат талбай бүхий барилгыг ногоон барилгын үнэлгээний системээр үнэлж гэрчилгээжүүлсэн бөгөөд цаашид энэ тоо улам өсөж, улс орнуудын энгийн шаардлага болон өөрчлөгдөх хандлагатай байна.


Иймээс хөрөнгө оруулагчид эрчим хүч болон усны хэмнэлттэй хэмнэлттэй, байгаль орчин эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хариуцлагатай хэрэглээг дэмжсэн, хүлэмжийн хийн ялгаралыг бууруулсан төслүүдэд хөрөнгө оруулах сонирхолтой болжээ. Өөрөөр хэлбэл дэлхийн эдийн засаг, санхүүжилт тэр чигээрээ тогтвортой, ногоон тодотгол бүхий төсөл, бизнес рүү чиглэж байна.

Олон улсад мөрдөгдөж буй ногоон эдийн засгийн нийтлэг зарчим, шалгуур үзүүлэлтийг нэвтрүүлж, ногоон эдийн засгийг хөгжүүлэх зорилгын хүрээнд “Монгол улсын ногоон таксономи” баримт бичгийг 2019 оны 12-р сард Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпорац зэрэг байгууллагын бодлогын дэмжлэгтэйгээр буюу Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан байна.

Монгол орны банк санхүүгийн системд ногоон барилгын зээлийн гол шалгуур нь “Барилгын Эрчим хүчний гэрчилгээ” - нд тавигдах голлох шалгуурууд байна.

Барилгын эрчим хүчний хэрэглээний шалгуур үзүүлэлтийн тооцоог БНБД 25-01-20 Барилгын дулаан хамгаалалт нормд заасны дагуу тооцох бөгөөд дараах ангиллын барилгад эдийн засгийн дэмжлэг үзүүлнэ.

	<table border="1"> <tr> <td>Хэмжээ:</td> <td>500 сая төгрөг хүртэл</td> </tr> <tr> <td>Хүү:</td> <td>12.00%, 13.20%, 14.40%</td> </tr> <tr> <td>Хугацаа:</td> <td>240 сар хүртэл</td> </tr> <tr> <td>Шимтгэл:</td> <td>Олгосон зээлийн 1%</td> </tr> <tr> <td>Урьдчилгаа:</td> <td>20%</td> </tr> </table>	Хэмжээ:	500 сая төгрөг хүртэл	Хүү:	12.00%, 13.20%, 14.40%	Хугацаа:	240 сар хүртэл	Шимтгэл:	Олгосон зээлийн 1%	Урьдчилгаа:	20%		<p><b>Амины орон сууц барих, засварлах зээл</b></p> <p>Эрчим хүчний хэмнэлт 20-40% бол <b>14.4% хүүтэй</b>                  Эрчим хүчний хэмнэлт 41-60% бол <b>13.2% хүүтэй</b>                  Эрчим хүчний хэмнэлт 61% дээш бол <b>12% хүүтэй</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Захиалгын гэрээ, Худалдах худалдан авах гэрээ</li> <li>Эрчим хүчний хэмнэлттэй хувийн сууц болохыг тодорхойлсон эрх бүхий байгууллагын үнэлгээ</li> </ul>
Хэмжээ:	500 сая төгрөг хүртэл												
Хүү:	12.00%, 13.20%, 14.40%												
Хугацаа:	240 сар хүртэл												
Шимтгэл:	Олгосон зээлийн 1%												
Урьдчилгаа:	20%												
	<table border="1"> <tr> <td>Хэмжээ:</td> <td>1 тэрбум төгрөг хүртэл</td> </tr> <tr> <td>Хүү:</td> <td>16.20%</td> </tr> <tr> <td>Хугацаа:</td> <td>240 сар хүртэл</td> </tr> <tr> <td>Шимтгэл:</td> <td>0.8 %</td> </tr> <tr> <td>Урьдчилгаа:</td> <td>30%-иас дээш</td> </tr> </table>	Хэмжээ:	1 тэрбум төгрөг хүртэл	Хүү:	16.20%	Хугацаа:	240 сар хүртэл	Шимтгэл:	0.8 %	Урьдчилгаа:	30%-иас дээш		<p><b>Ногоон хувийн орон сууцны зээл</b></p> <p>Хувийн орон сууц барих зээлийн хувьд барилга ажлын төсөв                  Эрчим хүчний хэмнэлттэй хувийн сууц болохыг тодорхойлсон <b>эрх бүхий байгууллагын дүгнэлт</b></p>
Хэмжээ:	1 тэрбум төгрөг хүртэл												
Хүү:	16.20%												
Хугацаа:	240 сар хүртэл												
Шимтгэл:	0.8 %												
Урьдчилгаа:	30%-иас дээш												
	<table border="1"> <tr> <td>Хэмжээ:</td> <td>300 сая төгрөг хүртэл</td> </tr> <tr> <td>Хүү:</td> <td>EDGE Certified: Б.хүү + 4% EDGE Advanced, Carbon Zero: БХ + 2%</td> </tr> <tr> <td>Хугацаа:</td> <td>240 сар хүртэл</td> </tr> <tr> <td>Шимтгэл:</td> <td>1%</td> </tr> <tr> <td>Урьдчилгаа:</td> <td>20%, 30%</td> </tr> </table>	Хэмжээ:	300 сая төгрөг хүртэл	Хүү:	EDGE Certified: Б.хүү + 4% EDGE Advanced, Carbon Zero: БХ + 2%	Хугацаа:	240 сар хүртэл	Шимтгэл:	1%	Урьдчилгаа:	20%, 30%		<p><b>Ногоон АОС худалдан авах, барьж дуусгах</b></p> <p>Олон улсын <b>EDGE стандартын</b> батламжтай                  Эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээ <b>A++, A+, A, B</b> ангилалд байх.</p>
Хэмжээ:	300 сая төгрөг хүртэл												
Хүү:	EDGE Certified: Б.хүү + 4% EDGE Advanced, Carbon Zero: БХ + 2%												
Хугацаа:	240 сар хүртэл												
Шимтгэл:	1%												
Урьдчилгаа:	20%, 30%												
	<table border="1"> <tr> <td>Хэмжээ:</td> <td>Төслөөс хамаарна</td> </tr> <tr> <td>Хүү:</td> <td>12% - 15%</td> </tr> <tr> <td>Хугацаа:</td> <td>60 сар хүртэл</td> </tr> <tr> <td>Шимтгэл:</td> <td>0.5%</td> </tr> <tr> <td>Урьдчилгаа:</td> <td>20%</td> </tr> </table>	Хэмжээ:	Төслөөс хамаарна	Хүү:	12% - 15%	Хугацаа:	60 сар хүртэл	Шимтгэл:	0.5%	Урьдчилгаа:	20%		<p>эрчим хүчний хэрэглээ хамгийн багадаа 20%-иар хэмнэгдэхээр байх, эсвэл хүлэмжийн хийг 20 хувиас дээш бууруулсан байх</p> <p>Барилгын эрчим хүчний гэрчилгээ заавал гаргуулсан байх шаардлагатай.                  LEED (Silver), BREEM (Good), EDGE (Standard) сертификатай</p>
Хэмжээ:	Төслөөс хамаарна												
Хүү:	12% - 15%												
Хугацаа:	60 сар хүртэл												
Шимтгэл:	0.5%												
Урьдчилгаа:	20%												
	<table border="1"> <tr> <td>Хэмжээ:</td> <td>200 сая төгрөг хүртэл</td> </tr> <tr> <td>Хүү:</td> <td>12%</td> </tr> <tr> <td>Хугацаа:</td> <td>240 сар хүртэл</td> </tr> <tr> <td>Шимтгэл:</td> <td>0.5%, Урьдчилгаа 20% &lt; 0%</td> </tr> <tr> <td>Урьдчилгаа:</td> <td>20 %</td> </tr> </table>	Хэмжээ:	200 сая төгрөг хүртэл	Хүү:	12%	Хугацаа:	240 сар хүртэл	Шимтгэл:	0.5%, Урьдчилгаа 20% < 0%	Урьдчилгаа:	20 %		<p><b>Эрчим хүчний хэмнэлттэй АОС бариулах, хотхоны орон сууц худалдан авах</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Хөндлөнгийн аудиторын зардлыг <b>ХасБанк төлнө.</b></li> <li><b>180.0 сая төгрөг хүртэл түр барьцаа шаардахгүй /Барилга хөгжүүлэгчтэй хариуцлагын гэрээ байгуулна/</b></li> </ul>
Хэмжээ:	200 сая төгрөг хүртэл												
Хүү:	12%												
Хугацаа:	240 сар хүртэл												
Шимтгэл:	0.5%, Урьдчилгаа 20% < 0%												
Урьдчилгаа:	20 %												



**BASALTWOOL**  
МОНГОЛ БАЗАЛТ ХК

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТОЙМ



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байхаар Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодексийн зарчмыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд цаашид Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг хангах, хэвшүүлэх, тогтвортой байдлыг бий болгох зорилттойгоор ажиллана.

2024 онд Төлөөлөн удирдах зөвлөл ээлжит 4 хурал, эчнээ санал хураалт 2 удаа хийж 10 тогтоол гаргасан байна.

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Монгол Базальт ХК 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр 80% ирцтэйгээр зохион байгууллаа.

1

### ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН



Л.Ариунболд



Б.Шаравсамбуу



Хан Гю Бунг



П.Сайнбилэг



Г.Ганзориг



А.Энхгэрэл



Ш.Энхтөр



П.Нямдорж



Ч.Зоригтбаатар

### ТУЗ-ИЙН ХОРООД

1. Нэр дэвшүүлэх хороо
2. Аудитын хороо
3. Цалин урамшууллын хороо
4. Эрсдлийн удирдлагын хороо

2

### “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС” ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН


Кодексын зарчим	Авбал зохих оноо	Үнэлгээ	Үнэлгээний хувь
ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%
ТУЗ-ийн дэргэдэх хороод тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%
Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6	100%
Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100%
Эрсдлийн удирдлага	8	8	87.5%
Эрх бүхий албан тушаалтын цалин урамшуулал	6	6	100%
Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%
Компанийн соёл	6	6	100%
Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100%
<b>Нэгдсэн дүн</b>	<b>72</b>	<b>72</b>	

2024 оны компанийн засаглалын кодексын үнэлгээ:


**100%**

# ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

## ХУВЬЦААНЫ ХАНШ



## ХУВЬЦААНЫ ХАНШИЙН ГРАФИК



## Олгосон ногдол ашиг


Он	Нийт ногдол ашиг	Цэвэр ашигт эзлэх %	Нэгж хувьцаанд ногдох /₮/	Ногдол ашгийн өгөөжийн %
2019	225,668,000.00	68%	4.00	2%
2020	162,480,960.00	100%	2.88	2%
2021	964,166,530.00	60.2%	17.09	10%
2022	1,128,340,000.00	53.4%	20	9%
2023	1,184,757,000.00	96.1%	21₮	10.2%

Тайлант хугацаанд хоёрдогч зах зээлд арилжаалагдсан нийт хувьцааны дээд ханш нь 206₮, доод ханш нь 170.42₮ бөгөөд 2024 оны хаалтын ханш 197.84₮ байлаа.


Тайлант хугацаанд үнэт цаасны хоёрдогч зах зээлд сард дунджаар 144.5 мянган ширхэг буюу тайлант хугацааны туршид нийт 1734 мянган ширхэг хувьцаа 318.5 сая төгрөгөөр арилжаалагдлаа.

Мөн тус компани нь Санхүүгийн зохицуулах хорооны “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоолд 2024 оны 02 сарын 23-ны өдөр өөрчлөлт оруулсантай холбогдуулан 2023 оны ногдол ашиг болох 1,184,757,000 төгрөгийг ҮЦТХТ ХХК-р дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд 2024 оны 05 сарын 31-ний өдөр тараан байршууллаа.

## Ногдол ашгийн өсөлт /₮/



## 1 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ



## 2 НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭШИГЧИД

№	Нэр	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Л.Ариунболд	35.7%
2	П.Сайнбилэг	13.3%
3	А.Энхгэрэл	7%
4	А.Энхмаа	7%
5	А.Энхжин	7%




# ХҮНИЙ НӨӨЦ


Нийт ажилтаны 80% нь дээд боловсролтой болон МСҮТ төгссөн, 70% нь 3 жилээс дээш хугацаанд ажилласан нь хүний нөөцийн тогтвортой, чадварлаг баг бүрдсэнийг илтгэж байна. 2024 онд Хүний нөөцийн эргэцийн дундаж хувь **4.5%**-тай буюу хүний нөөц тогтвор суурьшилтай байгааг харуулж байна.



## Хүйсийн харьцаа



## Хүний нөөцийн харьцуулалт



## Харьцуулалт / сая төгрөг



# ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Монгол базальт ХК-ийн дулаан тусгаарлагч материалын үйлдвэр нь 2024 онд 2892,5 тонн хөвөн үйлдвэрлэлээ.

Шугам хоолойн дулаалгын цехэд нийт 8456 метр шугам, яндан хоолой, 1084,2 метр оёмол хөнжил дулаалга хийж гүйцэтгэлээ.

Чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын үйлдвэрт их бүтээн байгуулалт засвар шинэчлэлийн ажил өрнүүлж, тоног төхөөрөмжийн туршилт тохируулгын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Цаашид бид бүтээгдэхүүний чанарт онцгой анхаарч технологийн горимыг өндөр түвшинд мөрдүүлж, хүн хүчний нөөц суурийг бэлтгэх сургах, хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлыг чанд мөрдөж ажиллана.




# САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Үйлдвэрлэлийн шинэчлэл инновацийн үр дүнд чулуун хөвөн хавтангийн борлуулалтын үнээ 30-40% бууруулан хэрэглэгчдэд хүргэж байна. 2023 оны мөн үетэй харьцуулахад борлуулсан бүтээгдэхүүний тоо өсч, борлуулалтын орлого 22.3% өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Базальт ХК нь 2024 онд зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангах зорилгоор их бүтээн байгуулалтыг өрнүүлж үйлдвэрлэлийн шугам дамжлагаа хүчитгэн ажилласаны үр дүнд 310 мянга орчим боодол бүтээгдэхүүн борлуулсан байна.

## БОРЛУУЛАЛТ / САЯ.ТӨГРӨГ



Санхүү байдлын тайлангийн бусад үзүүлэлтүүдийг санхүүгийн аудитлагдсан тайлангаас үзнэ үү.

## "ТАЙВАНЬ УЛСРУУ БҮТЭЭГДЭХҮҮН ЭКСПОРТОЛЛОО."

Монгол Базальт ХК нь 2024 оны 05 сард Тайвань улсын **CHRONG YI COMPOSITE** компанитай Базальт файбер бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулсан ба гэрээний дагуу 2024 оны 3 дугаар улиралд бүтээгдэхүүнээ Тайвань улсын Таюань хотруу амжилттай экспортоллоо.



# НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО



БОНЗ-ын үнэлгээн дээр тулгуурлан компанийн үйл ажиллагаанд **Ризилэйнс консалтинг сэрвиз ХХК**-тай нэгдсэн менежментийн тогтолцооний 3 стандарт буюу ISO9001:2015 чанарын удирдлагын тогтолцоо, ISO14001:2015 Байгаль орчны удирдлагын тогтолцоо, ISO 45001:2018 хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог 2023 оны 2 дугаар улиралд үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан. Уг зөвлөх үйлчилгээний хүрээнд 2023 оны 07 сараас 2024 оны 03 дугаар сар хүртэлх 9 сарын хугацаанд 26 сэдвээр 108 цагийн сургалтад давхардсан тоогоор 70 ажилтанг хамруулсан ба нэгдсэн менежментийн тогтолцооны 7 дотоод аудиторыг сургалтад хамруулж гэрчилгээжүүлсэн байна. Мөн уг зөвлөх үйлчилгээний хүрээнд НМТ-ны 17 бичиг баримт, 57 журам, 203 маягтыг боловсруулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нэгдсэн менежментийн тогтолцооны баталгаажуулалтыг 2016 оны 01 сарын 27-нд менежментийн тогтолцооны олон улсын стандартуудаар баталгаажуулалт явуулж гэрчилгээжүүлэх, стандартын сургалт зохион байгуулдаг “МонСертф” ХХК-г сонгож аудитын үйл ажиллагааг 2024 оны 3 дугаар улиралд эхлүүлсэн.

“МонСертф” ХХК-ийн 3 аудитор 2 шатны аудит хийсэн үндсэн дээр “Монгол базальт” ХК-ийн “Чулуун хөвөн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, худалдаа” хамрах хүрээнд ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO 14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцоо, ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал менежментийн тогтолцооны олон улсын стандартыг нэвтрүүлснийг баталгаажуулсан анхдагч гэрчилгээг 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар олголоо.

## Хүлээгдэж буй үр дүн:

ISO 9001, 14001, 45001 стандартыг дагаж мөрдөсөнөөр дараах үр дүн бий болох юм.

**1.Үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх:** ISO 9001 стандартыг дагаж мөрдөх нь үйл явцыг оновчтой болгож, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлж, ерөнхий гүйцэтгэлийг сайжруулна.

**2.Байгаль орчны хариуцлага нэмэгдэх:** ISO 14001 гэрчилгээ нь компанийн эрхэм зорилго, алсын хараатай уялдуулан байгаль орчныг хамгаалах үүрэг амлалт, тогтвортой практик, байгаль орчны менежментийн үйл ажиллагааг сайжруулна.

**3.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн сайжруулах:** ISO 45001 гэрчилгээ нь ажилчдын аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, аюулгүй, эрүүл ажлын орчинг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулна.

**4.Нэр хүнд өсөх:** ISO стандартад нийцэж байгааг харуулах нь компанийн нэр хүнд, итгэлийг дээшлүүлж, үйлчлүүлэгчид, түншүүд болон оролцогч талуудын итгэлийг нэмэгдүүлнэ.

**5.Хууль эрх зүйн нийцлийг нэмэгдүүлэх:** Баталгаажуулалт нь зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөж, зах зээлд өрсөлдөх давуу талыг бий болгоно.



# БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЗАСАГЛАЛЫН СУУРЬ ҮНЭЛГЭЭ

Монгол Базальт ХК нь 2023 онд Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны хамтын ажиллагааны хүрээнд байгаль орчин, нийгэм, засаглалын материаллаг байдлын үнэлгээг “Ризилиенс Консалтинг Сервиз” ХХК -р гүйцэтгүүлж, компанийнхаа БОНЗ-ын асуудлуудыг нарийн тодорхойлж үнэлсэн.

## БОНЗ-ЫН БОДЛОГО



Тогтвортой бүтээгдэхүүн үйлдвэрлэл ба нийлүүлэлт



Тогтвортой үйл ажиллагаа



Тогтвортой хамтын ажиллагаа ба тайлагнал



## 2024 оны Байгаль орчны онцлох үзүүлэлтүүд:

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ	2023 ОН 927,139 кВт/цаг	2024 ОН 849,877 кВт/цаг	БУУРАЛТ 8.3% ↓
УСНЫ ХЭРЭГЛЭЭ	2023 ОН 3,993м3	2024 ОН 4689м3	ӨСӨЛТ 14.9% ↑
ТҮЛШНИЙ ХЭРЭГЛЭЭ	2023 ОН 176,284 л	2024 ОН 195,946 л	ӨСӨЛТ 11.1 ↑
ХОГ ХАЯГДАЛ -ЭНГИЙН	2023 ОН 325 тн	2024 ОН 468.9тн	ӨСӨЛТ 15% ↑
ХОГ ХАЯГДАЛ -АЮУЛТАЙ	2023 ОН 120 кг	2024 ОН 140 кг	ӨСӨЛТ 16.6% ↑
ДУЛААН ХАНГАМЖ	2023 ОН 2158 Гдж	2024 ОН 1882 Гдж	БУУРАЛТ 14.6% ↓

# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО


Монгол Базальт ХК нь НҮБ-ын “Даян дэлхийн гэрээ” болон Тогтвортой санхүүжилтийн холбоонд үүрэг, амлалт хүлээн нэгдэн орохоор зэхэж, бизнес ба хүний эрхийн зарчим, шаардлагуудыг компанийн менежментийн үйл ажиллагаанаас эхлэн өдөр тутмын үйл ажиллагаанд шат дараалан нэвтрүүлэн ажиллаж байна.



Тус компанийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн Тогтвортой хөгжлийн 17 зорилгуудын 12-ийн хэрэгжилтэд хувь нэмэр оруулж байна.

Чулуун хөвөн дулаалгын материалын үйлдвэрлэлээр тэргүүлэгч "Монгол базальт" ХК нь байгаль орчны хариуцлагын төлөөх амлалтаа биелүүлэхийн тулд тогтвортой хөгжлийн хэд хэдэн санаачилга хэрэгжүүлсэн. Тус компанийн эрхэм зорилгын дагуу галын аюулгүй байдал, эрчим хүчний хэмнэлт, тав тухыг хангах тогтвортой шийдлүүдийг санал болгохын сацуу тогтвортой хөгжил, дахин боловсруулалтын хэд хэдэн гол санаачлагыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Тус компани нь байгаль орчны тогтвортой байдалд хувь нэмэр оруулах, дугуй эдийн засгийн зарчимд нийцүүлэх зорилготой чулуун хөвөнгийн хаягдалыг дахин боловсруулах хөтөлбөрийг эхлүүлсэн.

SOUND  
ABSORBENT



FIRE  
RESISTANT



WATER  
REPELLENT



SDG 17:  
үр дүнтэй хамтын ажиллагаанд оролцох

# ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СХЕМ



SDG 13: Нүүрс хүчлийн хий бага ялгаруулах барилга, байгууламж үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ



SDG 7: Үйлдвэрийн болон оффисын барилгын фасад засвар шинэчлэл хийж эрчим хүчний хэмнэлттэй болсон



SDG 6: Ашигласан усны нөөцийн сан байгуулж усны дахин хэрэглээг нэвтрүүлж үйлдвэрт саарал усыг хэрэглээнд оруулсан




SDG 13: Үйлдвэрийн гарах хоолойн уудын филтер системийг дахин сайжруулж нүүрс хүчлийн хийн ялгаралыг стандартаас бага хэмжээнд хүргэсэн



SDG 8: Аюулгүй ажиллагааг сайжруулж, сул зогсолтыг бууруулсан



SDG 9: Бат бөх, гал тэсвэртэй барилга байгууламжийг нэмэгдүүлэх



SDG 8: Тогтвортой ажлын байр, эдийн засгийн өсөлтийг дэмжих



SDG 13: Нүүрстөрөгчийн хэмнэлттэй барилга, байгууламж үйлдвэрлэлийг идэвхижүүлэх



SDG 11: Орлогд нийцсэн орон сууц, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих



SDG 7: Эрчим хүчний хэмнэлттэй барилга, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх



SDG 6: Тариалалтын усны хэрэглээг багасгах



SDG 2: Тогтвортой хүнсний үйлдвэрлэлийг бий болгох



SDG 12: Хог хаягдалгүй үр ашигтай үйлдвэрлэл



SDG 3: Дуу чимээний тусгаарлалттай барилга байгууламжийг нэмэгдүүлэх



Тогтвортой хөгжлийн зорилт



Бүтээгдэхүүний хэмжүүр

## ТОГТВОРТОЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА

### ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН ХОЛБООНД ГИШҮҮНЭЭР ЭЛСЛЭЭ.

Монгол улсад анхны чулуун хөвөнгийн үйлдвэр байгуулсан Mongol Basalt JSC нь компанийн философийн цөмөөр Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалууд нягт уялдаатай ажлууд хийдэг билээ. 2014 онд гэр хорооллын айлуудын дахин дулаалгын аянууд санаачласнаас гадны барилгын салбарын эрчим хүчний хэрэглээг бууруулах, агаар мандлын нүүрсхүчлийн хийг бууруулах, тойрог эдийн засгийг хэрэгжүүлэхээр BASALTCycle хөтөлбөр зэргийг идэвхтэйгээр хэрэгжүүлж байгаа. Холбоонд нэгдэн орсноор Тогтвортой хөгжлийн зорилтуудад хувь нэмрээ оруулж, нийгэмд тулгарч буй уур амьсгалын өөрчлөлтийн томоохон сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, аюулгүй, эрүүл, уур амьсгалд илүү тэсвэртэй, тогтвортой нийгмийг цогцлоох эрхэм зорилготой байгаа билээ.



### БАРИЛГЫН ДЭЛХИЙН ХОЛБОО (GLOBALABC)-Д ГИШҮҮНЭЭР ЭЛСЛЭЭ.

GlobalABC нь олон улсын, олон талт түншлэл бөгөөд янз бүрийн платформ, санаачлага, оролцогчдын хамтарсан байгууллага юм. Энэ нь Парисын хэлэлцээрийн зорилтуудын дагуу хамтын ажиллагааг бий болгох, уур амьсгалын үйл ажиллагааг өргөжүүлэх, барилга байгууламж, барилгын салбарын уян хатан байдлыг нэмэгдүүлэх зорилготой юм. Монгол Базальт ХК нь шинэ гишүүний хувьд мэдээллийн хүртээмж, байгууллагын чадавхи, бодлогын хүрээ, санаачлагын зохицуулалт, санхүүжилтийн механизм зэрэг гол сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж байна. GlobalABC нийгэмлэгтэй хүчээ нэгтгэснээр бид салбарын нөлөөллийг бууруулах, дасан зохицох чадавхийг ашиглаж, утаагүй, үр ашигтай, уян хатан барилгуудыг хүн бүрт дэмжих зорилготой.



# BASALTCYCLE ДАХИН БОЛОВСРУУЛАХ ХӨТӨЛБӨР




## SDG 12: NET ZERO BASALTCYCLING ROADMAP

Түүхий эд  
/базальт, шохойн  
чулуу/



Basaltwool дулаан  
тусгаарлагч хавтангийн  
үйлдвэрлэл



Барилга



SDG 13:  
Нүүрстөрөгчийн хэмнэлттэй  
барилга, байгууламжийн  
үйлдвэрлэлийг дэмжих





SDG 11:  
Хямд үнэтэй орон сууц, эрчим  
хүчний хэмнэлтийг дэмжих



SDG 7:  
Эрчим хүчний хэмнэлттэй  
барилга байгууламж,  
үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

Тээвэрлэлт




Барилга нураалт



SDG 3:  
Дуу чимээний тусгаарлалттай  
барилга байгууламжийг  
нэмэгдүүлэх



Дахин  
боловсруулсан  
түүхий эд



Үйлдвэрлэлийн  
хог хаягдал

Барилгын хаягдал чулуун хөвөн,  
үйлчлүүлэгчдээс хаягдсан  
материалыг тээвэрлэх

Монгол Базальт ХК нь өндөр чанарын, ногоон барилгын дулаалгын материалуудыг Европын Холбооны галын А1 зэрэглэлийг хангаж нийлүүлж байна. Хариуцлагатай барилгын салбарыг Инновациар дэмжинэ.

2024 онд Нийт 3 худалдан авагч байгууллагаас 1306 кг чулуун хөвөнгийн хаягдал 25кг урлоны хаягдал буцаан авсан.

# НОГООН ТӨСӨЛ GROWOOL



Чулуун хөвөн ашиглан гидропоник технологиор тариалалт хийх нь байгаль цаг уураас хараат бус жилийн дөрвөн улирал тогтвортой ургац хураах боломжыг бүрдүүлэх болно.

Монгол Базальт ХК-ийн хамт олон анхны монгол хэл дээрх хөрсгүй тариалалтын гидропоник технологийн зааварчилгаа, гарын авлага номыг бэлтгэн, 2021 оны 11 сард худалдаанд гаргасан.

Монгол Базальт ХК нь 2019 оноос GROWOOL /ургамал тарих чулуун хөвөн/ старт апыг бойжуулан хадгалалт тээвэрлэлтээс үүсэх хүнсний ногооны хаягдалыг багасгах, усны хэрэглээ бага тариалалтын технологийг нэвтрүүлэх, хуурай сэрүүн уур амьсгалтай Монгол орны нөхцөлд байгаль цаг уураас хараат бус жилийн турш тогтвортой тариалалт хийх боломжтой шинэ технологи болох гидропоник технологийн талаар сургалт зөвөлгөө, гарын авлага, мэдээлэлийг иргэд аж ахуй нэгж, нийгэмд түгээн ажиллаж байна.



## ТОГТВОРТОЙ ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Монгол улсын хүнсний ногооны 80%-г импортын бүтээгдэхүүн эзлэж байна. COVID-ын нөлөөгөөр монгол улсад өргөн хэрэглээний хүнсний ногооны үнэ нэмэгдэж, хомсдол бий болж буй энэ цаг үед бид иргэн бүр хүнсний ногоогоо өөрөө ургуулах боломжтойг сурталчилан таниулж байна.

Монгол улсын цэвэр усны хэрэглээний 12%-г усалгаатай тариалан буюу газар тариаланд ашигладаг бөгөөд базальт чулуун хөвөн ашигласнаар газар тариаланд ашиглаж буй усыг 80-90%, тариалалтын талбайн хэмжээг 70% хүртэл хүртэл бууруулах бүрэн боломжтой юм.

Мөн жилийн дөрвөн улиралд уур амьсгал, цаг агаарын нөлөөлөлөөс шалтгаалахгүйгээр тогтвортой хүнс үйлдвэрлэх боломжтой тул тогтвортой хөгжлийн зорилтын 2, 6 болон 15 дугаар зорилтуудыг бүрэн хангаж чадсан **НОГООН** төсөл юм.



2 ӨЛСГӨЛӨНГ  
ЗОГСООХ



6 БАТАЛГААТ УНДНЫ УС  
АРИУН ЦЭВРИЙН  
БАЙГУУЛАМЖААР  
ХАНГАХ




15 ХУУРАЙ ГАЗРЫН  
ЭКО СИСТЕМИЙГ  
ХАМГААЛАХ



## 2024 ОНД ЭХЛҮҮЛСЭН ТӨСӨЛ:

ГИДРОПНИК ТАРИАЛАЛТЫН УХААЛАГ 4 УЛИРЛЫН ХҮЛЭМЖ




ХҮЧИН ЧАДАЛ:

**60-100 ТН/ЖИЛ  
УРГАЦ**



ХЭСЭГЧЛЭН УГСРАХ БАЗАЛТ СЭНДИЧ ХАВТАНГИЙН ҮЙЛДВЭР



ХҮЧИН ЧАДАЛ:

**720,000 М2/ЖИЛ  
ХАВТАН**



# ШИНЖЛЭХ УХААН, БОЛОВСРОЛ ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ



## TEDXDARKHAN

Тус компанийн гүйцэтгэх захирал А.Энхгэрэл TedxDarkhan Salon "ReImagine" арга хэмжээний илтгэгчээр оролцсож, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх арга барилаа ШИНЭЭР ТӨСӨӨЛСНӨӨР хэрхэн БИД БҮГДЭД бий нөөцүүдийг хөшүүрэг болгон ашиглах боломжтой талаар туршлагаасаа хуваалцлаа. Арга хэмжээний үеэр Монгол Базальт ХК бүтээгдэхүүн үйлчилгээгээ Дархан хотын иргэдэд танилцуулсан ба үзэгчид дундаас 3,500,000 төгрөгийн Базальт чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын эзнийг тодрууллаа.



## СУРГАЛТ

Монгол Базальт ХК нь 2024 оны 01 сард Дархан уул аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Дархан уул аймгийн эмэгтэйчүүдийн холбоотой хамтран Утаагүй Дархан төслийн хүрээнд Термохаус Пассив сургалтын төвийг байгуулж Агаар орчны бохирдолыг бууруулах дахин дулаалгын болон Пассив барилгын сургалтуудыг МУИС-ын Амарбаяр професортой хамтран 2 удаа зохион байгуулаад байна.



## ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол улсын зөвлөх архитектур Б.Батжавтай хамтран ногоон архитектур, ногоон барилгын материал, Ногоон барилга агуулгын хүрээнд хамтран ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд Ногоон барилгын тухай мэдлэг ойлголтыг түгээн дэлгэрүүлэх компани ажлуудыг зохион байгуулж байна.

# ШИНЖЛЭХ УХААН, БОЛОВСРОЛ ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ



## “ШИНЖЛЭХ УХААНД СУУРИЛСАН ХӨГЖЛИЙН ТҮНШЛЭЛ” ФОРУМ 2024

Инновацад суурилсан хөгжлийн төлөөх түншлэлийн форум нь Дархан-Уул аймгийн төдийгүй Төвийн бүсийн хэмжээнд тулгамдаж буй сорилтуудыг шийдвэрлэхийн тулд төр, хувийн хэвшил, их сургууль, шинжлэх ухааны байгууллагууд нэгдэн хамтын ажиллагаагаа өрнүүлэх, шинэлэг шийдлүүдийг хамтран бүтээх платформыг бий болгох явдал юм.

Тус форумын үеэр Монгол Базальт ХК-ийн гүйцэтгэх захирал А.Энхгэрэл Зочин илтгэгчээр оролцож "Чадамжтай хүний нөөц бий болгоход тулгамдаж буй асуудал, шийдэл" сэдвээр илтгэл тавилаа.



## ИННОВАЦ, ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮР АШИГ, СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН

Сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх сүүлийн үеийн технологийг танилцуулж, салбарын мэргэжилтнүүдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэх IREEE 2024 Инновац, сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний үр ашгийн олон улсын үзэсгэлэн, конференцыг Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хорооноос санаачлан USAID-ын дэмжлэгтэйгээр Нийслэлийн инновацийн газар, МҮХАҮТ-тай хамтран 2024 оны 5 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Мишээл экспод зохион байгуулсан ба Монгол Базальт ХК амжилттай оролцож шилдэг байгууллагаар тодорлоо.




# ШИНЖЛЭХ УХААН, БОЛОВСРОЛ ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ



## УЛААНБААТАР БАРИЛГА-2024

“Мишээл Экспо”-с жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Улаанбаатар Барилга-2024 үзэсгэлэн арга хэмжээнд амжилттай оролцлоо. Уг үзэсгэлэн арга хэмжээ нь 2 төрөл буюу Барилга орон сууц, Барилгын материал шинэ технологи гэсэн сэдвүүдээр зохион байгуулагдаж нийт 3000 гаруй хэрэглэгчдэд мэдээлэл зөвлөгөөг хүргэлээ.



## “ДАРХАН БАРИЛГА ЭКСПО”-2024

Дархан- Уул аймгийн барилгын салбарын хамгийн том “ДАРХАН БАРИЛГА ЭКСПО” цуврал үзэсгэлэнд Монгол Базальт ХК оролцож Дархан -Уул аймгийн хэрэглэгчдэдээ ойртон очиж дахин дулаалгын зөвлөгөө мэдээллийг хүргэж ажиллаа.

# ШИНЖЛЭХ УХААН, БОЛОВСРОЛ ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ



## "BUILD MONGOLIA 2024"

"Монгол орноо хамтдаа бүтээн байгуулцгаая" уриан дор Build Mongolia 2024 - Олон улсын барилга, уул уурхай, эрчим хүч, дэд бүтэц, дэвшилтэт технологийн 4 дэх удаагийн үзэсгэлэн 2024 оны 4 сарын 24-26ны өдрүүдэд Степпе-Арена буюу Мөсөн Өргөөнд амжилттай зохион байгуулагдаж Монгол Базальт ХК амжилттай оролцлоо.



## BARILGA EXPO -2024

Монгол Улсад барилгын салбар үүсэж хөгжсөний 98 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан 36 дахь удаагийн BARILGA EXPO барилгын үзэсгэлэн яармаг 9-р сарын 6-8 өдрүүдэд уянт-Ухаа ордонд болж өндөрлөлөө.

Дэлхий нийтээрээ ногоон барилга, тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж байгаа энэ цаг үед ногоон бүтээн байгуулалтыг дэмжиж, илүү нийгмийн хариуцлагатай байхыг салбарынхандаа уриалан "Build smart ..." уриа дор энэ жилийн үзэсгэлэн зохион байгуулагдсан ба Монгол Базальт ХК амжилттай оролцлоо.

# ШИНЖЛЭХ УХААН, БОЛОВСРОЛ ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ



## НОГООН ТЕХНОЛОГИ-2024

Орчны бохирдлыг багасгах, байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг сурталчлан таниулах “Ногоон технологи-2024” үзэсгэлэнг энэ сарын 18-19-нд Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан ба Үзэсгэлэнд байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж, байгууллага, иргэд, олон нийт, олон улсын байгууллага, төрийн болон нутгийн захиргааны байгууллагууд болон Монгол Базальт ХК амжилттай оролцлоо.



# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА -БОЛОВСРОЛ / СПОРТ ДЭМЖЛЭГ



## "МОНГОЛ ИНЖЕНЕР"-2024

Энэхүү үйл ажиллагаа нь оюутан залуус, багш судлаач, инженерүүдийн мэдлэг, ур чадвар, инженерчлэлийн оновчтой шийдлийг дэмжих, судалгааны ажлын үр дүнг түгээн дэлгэрүүлэх, бизнесийн байгууллага - их, дээд сургуулийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой. "МОНГОЛ ИНЖЕНЕР-2024" нэгдсэн үйл ажиллагааны хүрээнд CAD/CAE/CAM улсын олимпиадыг амжилттай зохион байгуулсан ба Монгол Базальт ХК ерөнхий ивээн тэтгэгчээр оролцож, Монгол Базальт ХК-ийн инженерүүд шүүгчээр ажиллалаа.

Барилга, архитектурын сургууль болон "Монгол базальт" ХК хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа. Хамтын ажиллагааны хүрээнд бид дараах чиглэлүүдээр хамтран ажиллах болно. Үүнд:

1. Дадлагажигч оюутан бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлэх.
2. Цалинтай оюутан, тэтгэлэгт хөтөлбөр.
3. Мэргэжлийн техникийн семинар, хурал, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний хурал, уралдаан тэмцээн хамтран зохион байгуулах.
4. Мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой судалгаа хамтран хэрэгжүүлэх.
5. Хоёр талын гадаад хамтын ажиллагааг харилцан дэмжих.
6. Харилцан мэдээ, мэдээлэл солилцох.
7. Кредит цагтай сургалтын хөтөлбөр хамтран гаргах..



# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА - БОЛОВСРОЛ / СПОРТ ДЭМЖЛЭГ



## **BASALTCUP НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГ**

Монгол Базальт ХК нь Монгол улс дахь хоккейн спортыг хөгжүүлэх зорилгоор хүүхэд залуучуудын дунд “BASALT HOCKEY CUP” тэмцээнийг зохион байгуулж, дэмжин ажилладаг ба нийгмийн хариуцлагын хүрээнд тамирчин, суралцагч нарт тэтгэлэг олгох шийдвэрт үндэслэн Монголын хоккейн Үндэсний шигшээ багийн тамирчин Д.Лхагвадорж, Д.Цэнгэл нар Канадын Онтарио мужийн коллежийн “Crystal Beach” багт уригдаж суралцан тоглох тэтгэлэг авсанд нь баяр хүргэж тус бүр 4000 канад долларын тэтгэлэгийг онгоцны тийзийн хамт олгов.

## **ХАНДИВ ТУСЛАМЖ**

Монгол Базальт ХК нь 2024 оны эхний 3 улиралд компанийн 25 ажилтандаа нийт 50 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгов.



# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА - ХҮҮХЭД БАГАЧУУД / ОЛОН НИЙТ



## “НОГООН ХОТ МИНИЙ ИРЭЭДҮЙ” гар зургийн уралдаан

Монгол Базальт ХК-ийн жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг Ногоон хот миний ирээдүй сэдэвт гар зургийн уралдааныг 6-12 насны хүүхдүүдийн дунд амжилттай зохион байгуулж шилдэг 20 бүтээлийг мэргэжлийн шүүгчдийн бүрэлдэхүүнээр шалгаруулж, шагналыг гардууллаа.



# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА - ХҮҮХЭД БАГАЧУУД / ОЛОН НИЙТ

## "ФЭЙСБҮҮК АЗТАН"

Монгол Базальт ХК 2024 онд "Хилэнт эх" хэмээх Модон Луу жилийн Сар шинийн баяр болон Их Монгол Улс байгуулагдсаны 818 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113 жил, Ардын хувьсгалын 103 жилийн ойн баярыг тохиолдуулан 7 сая төгрөгийн базальт чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын шагналын сан бүхий Фэйсбүүк азтан шалгаруулах уралдааныг зохион байгууллаа.

**BASALTWOOL**  
МОНГОЛ БАЗАЛТ ХК

**FACEBOOK**

# АЗТАН

**3,500,000₮**

**БАЗАЛТ ХАУЗ**  
ДУЛААЛГААР БАЙШИНГАА  
ӨЛГИЙДЭХ ЭРХИЙН БИЧИГ

Basaltwool  
1.9K likes · 2.1K followers

Message FOLLOW

Details  
Page · Company  
No. 132, 20th kh district, Ulaanba  
7511 4444  
monbasalt@rock

**BASALTWOOL**  
МОНГОЛ БАЗАЛТ ХК

Баяр хүргэе.

АЗТАН

ЛХАГВАА ЛХАГВАА

www.basaltwool.mn | monbasalt@rockwool.mn | 75114444, 77006768



## ШИНЖЛЭХ УХААН, БОЛОВСРОЛ ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ



Европын Холбоо, ЕСБХБ, МҮХАҮТ хамтран “Ногоон эдийн засаг, ногоон бизнес- Эрчим хүчний шилжилт” арга хэмжээг энэ сарын 11-13-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус арга хэмжээгээр “ЕСБХБ-ны эрчим хүчний салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт, ногоон зээлийн санхүүжилт ба ЖДБ-ийг ногоон зөвлөх үйлчилгээгээр хэрхэн дэмжиж байгаа талаар, Эрчим хүчний үйлдвэрлэлээс гарах хүлэмжийн хий, түүнийг ААН-н түвшинд хэрхэн тооцоолох, Эрчим хүчний яам болон БОУАӨЯ-наас баримталж буй бодлого, хувийн хэвшлийн оролцоо хэлэлцүүлэгт Монгол Базальт ХК оролцлоо.



Нийслэлийн гэр хорооллын агаар орчны бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Монгол Базальт ХК Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүдэд дахин дулаалга хийх замаар агаар орчны бохирдлыг бууруулах тухай сургалт мэдээлэл, зөвлөгөө өгч ажилладаг билээ. 2024 оны 12 дугаар сард уг ажлын хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 1 хорооны 100 айл өрхөд дахин дулаалгын сургалтыг зохион байгууллаа.



# ШИНЖЛЭХ УХААН, БОЛОВСРОЛ ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ



**CAREC Жендер ба Уур амьсгалын шагнал 2024-р Монгол Базальт ХК-ийн гүйцэтгэх захирал А.Энхгэрэл шагнууллаа.**

Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC)-ийн Жендэрийн уур амьсгалын шагнал гардуулах ёслол 2024 оны 11-р сарын 6-нд Казахстаны Астана хотноо зохион байгуулагдаж, CAREC-ын гишүүн орнуудын нэр хүндтэй 8 хувь хүн, 7 байгууллагад шагналыг гардууллаа.

Жендэрийн цаг уурын шагналууд нь CAREC-ийн жендэрийн шагнал олгох хөтөлбөрийн хоёр дахь хэсэг бөгөөд хуучнаар CAREC-ийн жендэрийн тэгш байдлыг ахиулах шагнал юм. Энэхүү шагнал нь Төв болон Баруун Азийн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, дасан зохицох, саармагжуулах чиглэлээр жендэрийн тэгш байдлыг хангахад чухал хувь нэмэр оруулж буй хувь хүн, байгууллагыг үнэлэх зорилготой юм.

Монгол Базальт ХК-ийн Гүйцэтгэх захирал А.Энхгэрэлийг Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах эрчим хүчний хэмнэлттэй барилгын материал үйлдвэрлэх, эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламжийн дахин дулаалга, шинэчлэлийн ажлыг манлайлан ажиллаж буйг өндөрөөр үнэлж энэхүү шагналыг гардууллаа.

Энэхүү нэр хүндтэй шагнал нь CAREC бүс нутагт жендэрийн тэгш байдал, уур амьсгалын тогтвортой байдлыг бэхжүүлэхэд оруулсан түүний онцгой хувь нэмрийг үнэлж буй хэрэг юм.

Мөн түүний “Дулаан өрх, Гэрэлт ирээдүй: Эрчим хүчний үр ашгийн Монгол дахь амьдралд үзүүлж буй нөлөө” сэдэвт илтгэл нь CAREC-ийн Жендэр ба Уур амьсгалын шагнал гардуулах ёслол дээр танилцуулах хоёр илтгэлийн нэгээр шалгарсан нь Монгол Базальт ХК нь Монгол Улсын тулгамдаад буй агаарын бохирдол түүнээс улбаатай олон асуудлыг шийдэж болох түлхүүр үйлдвэрлэл, Бүтээгдэхүүн, Хөгжүүлэлтийн үр дүн гэдгийг илэрхийлж байна.



# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА -БОЛОВСРОЛ / СПОРТ ДЭМЖЛЭГ

“Монгол базальт” ХК нь Барилга, архитектурын сургуулийн 65 жилийн ойн хүрээнд ирээдүйн инженер болохоор суралцаж байгаа оюутан залуус руу чиглэсэн олон үйл ажиллагааг санхүүжүүлэх, кредит цагтай сургалтын хөтөлбөр хамтран гаргах, Дадлагажигч оюутан бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлэх, цалинтай оюутан, тэтгэлэгт хөтөлбөрүүдийг урт хугацаанд хамтран хэрэгжүүлэхээ илэрхийлсэн бөгөөд эхний хамтран зохион байгуулах үйл ажиллагаа бол “Green Tiny House” улсын хэмжээний уралдаан юм. Энэхүү уралдаан нь Архитектур мэргэжлээр суралцаж буй оюутнууд “Тогтвортой хөгжлийн бодлого”-ын хүрээнд өөрсдийн мэдлэг, ур чадвараараа өрсөлдөх бөгөөд 92 баг амжилттай бүртгүүлж, эцсийн шалгаруулалт 2024 оны 12 сарын 1-нд боллоо.

Ч.Дэндэвдоржийн нэрэмжит “Барилгын материал”-ын улсын VII олимпиадыг 2024 оны 12 сарын 7-нд их, дээд сургуулийн оюутнуудын дунд уламжлал болгон зохион байгуулсан ба 10 их сургуулийн 160 гаруй оюутнууд Базальт фибер Арматур болон Базальт хялгасан фиберыг бетон хийц, зам гүүр, усан сан, нүхэн туннель зэрэгт хэрхэн хэрэглэх вэ? сэдвийн хүрээнд өрсөлдлөө.





**BASALTWOOL**  
МОНГОЛ БАЗАЛТ ХК



75114444, 77006768



[www.Basaltwool.mn](http://www.Basaltwool.mn)



Монгол улс, улаанбаатар хот, БГД, 20-р  
хороо, үйлдвэрийн тойруу-132

Hummer